



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 3 нэрийн нийт 31,397,886.00 (гучин нэгэн сая гурван зуун ерэн долоон мянга найман зуун наян зургаан) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг 8,000,000.00 (найман сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын харьяа Хэнтий аймаг дахь Шүүхийн шинжилгээний хэлтэст балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн нийт 24,000,000.00 (хорин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч генерал Ж.Болд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа О.Амарсанаа, Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3. Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн  
... дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТО БААЗ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАХ,  
ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт /км/	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Балансын нийт үнэ, бүртгэсэн үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)		Шилжүүлэн авах хуулийн этгээд
										Цаашид ашиглах жил	Нэг бүрийн үнэ (төгрөг)	
1	Хьюндай соната-7, 07-17 УН3 /КМННВ41ВВВА2618571/	2010/2022	166515	32,846,067.00	Ш	1	12,000,000.00	-	12,000,000.00			Шүүх шинжилгээний ерөнхий газар
2	Тоёота раув-4, 38-65 УНН /ЈТВD31V005218399/	2008/2022	118254	34,389,000.00	Ш	1	12,000,000.00	-	12,000,000.00			Цагдаагийн ерөнхий газрын харьяа Автобааз
3	Киа оптима, 30-04 УНЧ /КНАGE227395301307/	2008/2022	380652	31,397,886.00	Ш	1	31,397,886.00	31,397,886.00	-	8,000,000.00	8,000,000.00	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
	Нийт дүн						55,397,886.00	31,397,886.00	24,000,000.00		8,000,000.00	